

1980-1990-ээд ОНЫ ЗААГ ҮЕИЙН МОНГОЛЫН НИЙГЭМ-УЛС ТӨРИЙН ХЯМРАЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА, ОНЦЛОГ

С.Базарпүрэв

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, доктор, дэд профессор

Г.Туяагэрэл

ХААИС-ийн Нийгмийн ухааны тэнхмийн багш, докторант

Монгол орны хөгжлийн замнал улс төрийн хямралын үйл явцаас ангид байгаагүй. Монголын улс төр, төр ёсны түүх нь улс төрийн хямралын ээдрээ нугачаан дунд бууран доройтож, өсөж өндийж ирсэн түүхэн нарийн төвөгтэй үйл явц байлаа. Монголын ард түмэн улс төрийн бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын хувь заяатай холбоотой нарийн төвөгтэй түүхэн сонголтын өмнө олонтоо тулж ирж байсан бөгөөд тэрхүү сонголтыг алдаж, онох алин боловч ямар нэг байдлаар хийж, тухайн цаг үед хуримтлагдсан улс төрийн хямралт үзэгдлийг тодорхой хэмжээгээр шийдвэрлэж байсан. Гэхдээ энэ хугацаанд алдаж, онохын дэнснээс онох нь хавьгүй их жин дарж байсан гэдэгтэй манай судлаачид нэг их санал зөрөхгүй бизээ. Энэ бүхнээс үзвэл Монголын улс төрийн түүхийг улс төрийн хямралын төвөгтэй олон асуудлыг даван туулж, шийдвэрлэж ирсэн түүх гэж үзэж болно. Хэдий тийм боловч Монголын түүхийн бүх цаг үед тохиож байсан улс төрийн хямралын асуудлыг бүхэлд нь шинжлэх бус, харин *өнгөрсөн* зууны 1980-1990-ээд оны зааг үеэр тус оронд тохиосон улс төрийн хямрал, түүнийг тойрсон асуудлыг тойм боловч шинжлэн үзэх нь энэ удаагийн судалгааны нэг чухал зорилт гэдгийг онцлох нь зүйтэй.

Өнгөрсөн зууны 80-90 ээд оны үе нь Монголын улс төрийн түүхийн *онцгой* гэж хэлж болох түүхэн цаг үе байсан. Монголын ард түмэн энэ үед нийгмийн хөгжлийн цаашдын хувь заяатай холбоотой хариуцлагатай сонголт хийхийн өмнөх эгзэгтэй нөхцөл байдалд байсан. Энэ үед дэлхийн социалист систем бүхэлдээ сүйрэн унахын урьдчилсан нөхцөл бүрэлдэн бий болж, энэ нь хэдийнээ илэрч ажиглагдах болсон юм. Өөрөөр хэлбэл, дэлхий дахины хүчний тэнцвэрийн нэг тулгуур болсон социалист системийг хамарсан улс төрийн гүнзгий хямрал тэр үед хэдийнээ нүүрлээд байсан хэрэг. 1980-аад оны дунд үеэс социалист систем бүхэлдээ задрах үйл явцын шинж тэмдэг тодорхой мэдрэгдэж эхэлсэн. Энэ нь Зүүн Европын социалист улс орнууд болох Польш, БНАГУ, Румын, Унгар, Чехсловак, Болгар зэрэг улс орнуудад тодоор илрэх болсон. Энэхүү хямралын хаялага манай хойт хөрш ЗХУ-д ч нөлөөлөн хүчээ авах болсон нь Монгол дахь улс төрийн хямралыг сэдрээн гүнзгийрэх урьдчилсан нөхцөл болсон юм. Тэр үеэс хүнд сурталт тоталитар системийн гүнд нэгэнт бүрэлдэн бий болсон сүйрлийн уршгийг саармагжуулан, социализмыг өөрийнх нь хүрээнд шинэчлэхэд чиглэсэн үйл явц манай хойт хөршид өрнөсөн. Үүнийг улс төр судлаачид "М.С.Горбачёвын өөрчлөн байгуулалт" хэмээн нэрлэдэг. Өөрчлөн байгуулалтын үйл явц социалист системийн хувь заяаг сүйрлийн ангалаас зайлуулж чадаагүйгээр үл барам, харин ч түүний мөхлийн явцыг хурдасган Зүүн Европын болон Азийн зарим улс оронд өрнөсөн ардчиллын үйл

явцыг түргэтгэхэд хүчирхэг нөлөө, түлхэц болсон байна.⁶² Ингэж социалист систем бүхэлдээ задарч, ЗХУ-ын шинэтгэлийн үйл явц эрч хүчээ авч өрнөсөн нь түүнтэй хөрш зэргэлдээ Монгол орны хувьд олон арван жил хуримтлагдсан улс төрийн хямралыг шийдвэрлэх таатай угтвар нөхцөл болсон.

Үүнтэй уялдан 1980-1990 ээд оны зааг үеийн Монгол дахь улс төрийн хямралын урьдчилсан нөхцөл, шалтгааны тухай асуудал гарч ирж байгаа юм. Улс төрийн хямралын шалтгааны тухай авч үзэхийн өмнө хямралын угтвар нөхцөлийн тухай асуудлыг зайлшгүй авч үзэх хэрэгтэй. Улс төрийн шинжлэх ухааны ном сурах бичгүүдэд “улс төрийн хямралын урьдчилсан угтвар нөхцөл” хэмээх ойлголтыг хямралд хүргэх нийгмийн болон улс төр, эдийн засаг, байгаль, экологи, соёл, ухамсар, нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлсийн үйлчлэн орших нийтлэг шинжийн цогц нийлбэр, тэдгээрийн шууд нөлөөлөл гэж тайлбарладаг.

Улс төрийн хямралын угтвар нөхцөлийн үйлчлэл нь тогтолцооны шинжтэй байдаг. Тэрхүү нөлөөллийн тогтолцоог улс төрийн шинжлэх ухаанд *нэгд*, эдийн засаг, улс төрийн гадаад орчны хүрээнд бүрэлдэн тогтсон түүхэн бодит нөхцөл байдлын шинж онцлог, түүний нөлөөллийн өвөрмөц төлөв байдал; *хоёрт*, нийгмийн дотоод амьдралын эдийн засаг, улс төрийн болон нийгэм сэтгэл зүй, соёл, ухамсрын хүрээнд бий болсон бодит нөхцөл байдал, хөгжлийн хүрсэн төвшин, түүний гүнд хуримтлагдсан зөрчлийн илрэн үйлчлэх шинж байдал; *гуравт* нийгмийн бүх хүрээ салбарт явагдаж буй хувьсал, өөрчлөлтийн үйл явцын шинж онцлог, зөрчлийг шийдвэрлэсэн байдал төлөв зэргийг багтаадаг. Улс төрийн хямралын угтвар нөхцөлийг объектив, субъектив, дотоод гадаад, шууд ба дам гэх зэргээр ялган үздэг. Энэ удаад тухайн үеийн Монгол дахь улс төрийн хямралын гадаад болон дотоод угтвар нөхцөлийн тухай асуудлыг арай дэлгэрэнгүй тодруулан үзэх болно.

Улс төрийн хямралд хүргэх гадаад ерөнхий угтвар нөхцөлийн хүрээнд тухайн улс орны гадаад орчин түүний орон зайд бүрэлдсэн хүчин зүйлсийн бодит шинжүүдийг хамруулан үздэг бол дотоод ерөнхий угтвар нөхцөл гэдэгт аль нэг улс орны дотоод амьдралын бүх талтай уялдан бий болсон үзэгдэл, үйл явц түүний нөлөөллийн шинж байдлыг багтаан үздэг. Харин дээрх хүчин зүйлс хоорондоо харилцан хамааралтайгаар үүсэн бүрэлдэж, орон зай, цаг хугацааны хувьд давхцаж байдаг онцлогтой. Хямралын улс төрийн нөхцөл байдал гэдгийг судлаач Е.Стерн тодорхойлохдоо түүний дараах онцлог шинжийг авч үзсэн байна. Үүнд:

- ✓ Засгийн эрхийг хэрэгжүүлж байгаа улс төрийн субъектийн амьдрал үйл ажиллагаанд шуудаар аюул учруулж байх ёстой;
- ✓ Аюул занал учруулж байгаа нөхцөл байдлыг шийдвэрлэх гарцаагүй байдал нь хойшлуулшгүй шинжийг агуулсан байх ёстой;
- ✓ Энэ нөхцөл байдлаас гарах шийдэл нь тодорхой байх ёстой⁶³ гэж үзсэн байдаг.

⁶² В.Ф. Шебина. Противоречия перестройки. Л., 1989. С. 75

⁶³ Stern E. Crisis decisionmaking: A cognitive Institutional Approach. Stockholm, 1999.P. 15

Дээрх судлаачийн дурьдсан шинж тухайн үеийн Монголын нөхцөлд бүрэн илэрч байсан. Монгол орны хувьд энэ нь социалист гэгдэж байсан улс орнуудад явагдсан шинэчлэлийн үйл явц болон манай нийгмийн гүнд хуримтлагдсан зөрчил, бэрхшээл, хямралт нөхцөл байдалтай холбоотойгоор бүрэлдэн бий болсон. Монголчуудад сайн сайхан бүхний үлгэр жишээ, туршлага болон ойлгогдож байсан ЗХУ-ын дотоод, гадаад байдал 1989 оны эцэс 90 оны эхэн гэхэд тал бүрийн хямралд автаж, дагаж дууриах юмгүй шахам болж нэр, нөлөөгөө алджээ. Энэ байдал нь улс төрийн сэтгэлгээ, тогтолцоогоо, явж байгаа замаа хянаж үзэхийн зайлшгүйтэй монголчуудыг гэнэдэж осолдмоор огцом золгуулжээ.⁶⁴

Үүнтэй уялдан манай зарим улс төрч, судлаачид “М.С.Горбачевын өөрчлөн байгуулалтыг Монголд бүрэлдсэн улс төрийн хямралын гол шалтгаан болж өгсөн гэж үздэг. Өөрчлөн байгуулалт нь манайд ужигран хуримтлагдсан улс төрийн хямралыг тодрон илрэхэд гол нөлөө үзүүлсэн болохоос биш, шууд шалтгаан нь хараахан биш юм. Иймд монголд илэрсэн улс төрийн хямралын үйл явцыг гагцхүү тус орны нийгмийн дотоод бодит учир шалтгаан, хүчин зүйлсийн нөлөөллийн хүрээнд авч үзэн тайлбарлах нь зохистой юм. Ингэхлээр 1980-1990 ээд оны зааг үеэс бугшин хуримтлагдсан улс төрийн хямрал нь манай оронд удтал оршин үйлчилж байсан хүнд сурталт, захиран тушаах тогтолцооны гүн дэх гажуудлын бүхий л үйл явцаар урт хугацааны туршид бэлтгэгдсэн жам ёсны үзэгдэл, нийгмийн тоталитар дэглэмийн өөрийнх нь гарцаагүй бүтээгдэхүүн байсан юм. Энэ тухай судлаач Ж.Болдбаатар, Д. Лүндээжанцан нар бичихдээ: “... манайд 1980-1990-ээд оны зааг дээр болсон ардчилсан эргэлт нь ямар нэг улс төрийн хүчин, мэргэн цэцэн хүний ухаарлын асуудал биш, харин бүхэл бүтэн монголын нийгмийн ухаарлын асуудал, дэлхийн социалист системийн ухаарлын хаялага, үүнийг тосон хүлээж авсан монголын ард түмний зүтгэл чармайлтын үр дүн байв”⁶⁵ гэсэн байдаг.

Монгол дахь 1980-1990 ээд оны зааг үеэс социалист орнуудад тулгарсан хямралын нийтлэг шинжүүд монголын нийгэмд тодорхой илэрч байв. Энэ нийтлэг шинж нь марксизм-ленинизмийн онол сургаалд үндэслэсэн улс төрийн тоталитар дэглэмийн хямрал, дан ганц нийгмийн өмчид тулгуурласан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн хямрал, эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан коммунист бие хүний оюун санаа, ёс суртахууны хямралаар тус тус илэрч байсан. Тэгэхдээ нийгмийн амьдралын бүхий л салбарт хамаатай дээрхи хямралын гол уг сурвалж нь зөрчил, илэрсэн хэлбэр нь зогсонги байдал; үйлчлэх байдал нь гажуудал-саатуулагч механизм болж байсан.⁶⁶

Хямрал гажуудлын гол эх сурвалжийн асуудлыг манай судлаач К.Зардыхан, Г.Чулуунбаатар нар тухайн үед нь “Социализм уу? Эсвэл хөгжлийн гажил уу?” хэмээх судалгааны нэг сэдэвт бүтээлдээ анхааран судалж, түүнийг Монголын нийгмийн амьдралын бүх хүрээнд удаан хугацааны туршид шийдвэрлэгдэхгүйгээр хуримтлагдан ужгирсан бодит зөрчлүүд гэж үзээд,

⁶⁴ Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил. (МЭӨ III-МЭ XX зуун). II-боть, УБ., 1995, 60 дахь тал.

⁶⁵ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997, 334 дахь тал.

⁶⁶ Д.Болд-Эрдэнэ. Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил. УБ., 2008, 46 дахь тал.

тэдгээрийг үндсэн, гол, тэргүүлэгч гэсэн гурван төрөлд хамруулан шинжилсэн байдаг ⁶⁷. Тэр дундаа хөгжлийн тухайн шатанд тэргүүн эгнээнд дэвшигдэн гарч нэн даруй шийдвэрлэх шаардлагатай болсон тэргүүлэгч зөрчлүүд нь Монголд улс төрийн хямралыг бий болгоход хүргэсэн ерөнхий угтвар нөхцөлийг бүрдүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж болно. Ийм зөрчлийн тоонд: а) эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжилд давамгайлж буй эрчимгүй арга ба эдийн засаг, нийгмийн эрчимтэй аргаар хөгжүүлэх шаардлагын хоорондын зөрчил; б) аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн түвшний зөрүүнээс үүссэн зөрчил; в) аж ахуйн үйл ажиллагаа, улс ардын аж ахуйн удирдлага дахь төвлөрөл ба ардчилсан эхлэлийн хоорондох зөрчил” ⁶⁸ зэргийг хамруулжээ.

Дээрх судлаачид Монголын нийгмийн гүнд хуримтлагдсан бодит зөрчлийг оношлон шинжлэх үндсэн дээр тус орны эдийн засаг, улс төр, нийгэм, оюун санааны хүрээнд зогсонги байдлын шинж төлөв нэгэнт бүрэлдэн бий болсоныг онцлон тэмдэглэж байлаа. Гэвч энэ дүгнэлттэй тухайн үедээ бүгд санал нэг байж чадаагүй юм. Тухайлбал улс төрчдийн зарим хэсэг нь зогсонги байдал гэдгийг ХАА-н салбараас бусдад нь хамруулан үзэхийг хүлээн зөвшөөрөхгүй байсан юм. Гэтэл зогсонги байдал нь Монголын нийгмийн гүнд бүрэлдэн бий болсон хямрал, гажуудлын илрэх үндсэн хэлбэр, тус оронд өрнөсөн ардчиллын үйл явцыг өдөөн түлхэгч ерөнхий угтвар нөхцөлийн төвлөрсөн илрэл болж байлаа.

“Зогсонги байдал” нь амьдрал дээр үйлчлэхдээ саатуулагч механизмын хэлбэрээр илэрч байлаа. Монголын нийгмийг бүхэлд нь “зогсонги байдал”-д оруулахад хүргэсэн гажуудал нь нийгмийн амьдралын эдийн засаг, нийгэм оюун санааны хүрээнд нийтлэг шинжтэй хуримтлагдаж, бодит байдал дээр 1980-1990 ээд оны улс төрийн хямрал бүрэлдэн, улмаар үндэсний ардчилсан хувьсгал гарахад хүргэсэн суурь шалтгаан болсныг манай судлаач, эрдэмтэд нэлээд дэлгэрэнгүй гаргаж тавьсан байдаг. Зөрчлийн шинж байдал нийгмийн амьдралын салбар, хүрээ бүрд өвөрмөц онцлогтой байсан боловч нийгэм, улс төр, оюун санааны хүрээний хурц зөрчлүүдийг улс төрийн хямрал үүсэхэд хүргэсэн гол шалтгаан гэж бас үзэж болно.

Нийгэм-улс төрийн хүрээнд нийгэм дэх ялгарлын зүй ёсны бодит үйл явцыг зохиомлоор будлиантуулж, нийгмийн олон бүлгүүдийг ажилчин малчин, хоршоолсон ард, сэхээтэн гэсэн гурван бүтцэд явцууруулан хязгаарлаж, тэдгээрт зэрэг дэв тогтоон ялгаварлаж, тэгш бус хандсан; нэг хүнийг тахин шүтэх, улс төрийн тогтолцооны төвд намыг тавьж, нам төр, аж ахуйн байгууллагын ажлын зааг хэрэг дээрээ үгүй болсон; төр, аж ахуйн байгууллагын ажилд намын байгууллага хөндлөнгөөс хэтэрхий оролцох болсон; ардчиллын наад захын хэм хэмжээ хумигдан, дураар авирлах, захиран тушаах арга, удирдлагын гол арга болж, хүнд суртал гаарсан; эдийн засгийг удирдахад захиргааны арга давамгайлж үүнийг дагалдан яам тусгай газрууд олшрон орон

⁶⁷ К.Зардыхан, Г.Чулуунбаатар. “Социализм уу? эсвэл хөгжлийн гажил уу?” УБ., 1991, 80-105 тал.

⁶⁸ К.Зардыхан, С.Дашдаваа. “Шилжилтийн үеийн нийгмийн зөрчлийн зарим асуудал”, “Намын амьдрал” 1988 № 10, 11-12 тал.

тоо нь нэмэгдэж, захиргааны аппарат томорч удирдлагын шат дамжлага нэмэгдэн, үргүй зардал, чирэгдэл өсөж, орон нутгийн санаачилга, бие даасан байдал боогдож, нийгмийн эрх ашиг хохирох болсон зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдээр дамжин хурц зөрчлүүд илэрч байлаа.

Оюун санаа, нийгэм сэтгэл зүйн хүрээнд үзэл санааны нэг л загварт аливаа асуудлыг тааруулан олон ургальч байдал, олон хувилбарт сэтгэлгээг үгүйсгэх, сэтгэлгээний залхуурал бэлэнчлэх, хуулбарлах, гоёж чимэх, идэвхгүй бусдын ам харах, шүүмжлэлтэй сэтгэх, ил тод байдлыг хязгаарлаж, үндэсний соёл, уламжлалаа дорд үзэн басамжлах, нийгмийн сэтгэл зүйг тайвшруулж, хууран мэхлэх худал сурталчлах зэрэг зөрчлийн олон хэлбэр илэрч байв.

Монголын нийгэмд бүрэлдэн бий болсон зөрчлийн сүлжээ нь нийгмийн анги бүлгүүдийн доторх ашиг сонирхолын ялгарлын үйл явцыг шинэ хэлбэрээр гүнзгийрэхэд хүргэсэн юм. Энэ нь: нэгдүгээрт, социалист системийг бүхэлд нь хамарсан хямрал түүнээс үүдсэн социалист гэгдэж байсан улс орнуудад болон ЗХУ-д өрнөсөн ардчилал, шинэчлэлийн нөлөөнөөс; хоёрдугаарт, монголын нийгмийн бүтцийг бүрдүүлэгч социал бүлгүүдийн амьдралын төвшин, нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, боловсрол мэдлэг мэргэжлийн төвшний харилцан адилгүй байдал, ялгаа зөрөөнөөс; гуравдугаарт, 1980-аад оны дунд үеэс тус орны нийгмийн амьдралын бүх талыг хамран илэрсэн хямрал гажуудал түүнээс үүдсэн өөрчлөлтийн дүнд нийгмийн социал бүтцэд гарсан задрал ялгарлын үйл явцаас; дөрөвдүгээрт, нийгмийн бүлгүүдийн үнэлэмж баримжаалал, үнэт зүйлсийн системд гарсан хувьсал өөрчлөлтөөс; тавдугаарт, тухайн үеийн засгийн эрх баригч бүлгийнхний үйл ажиллагаа тэдэнд хандах олон түмний хандлага итгэлийн уналт зэргээс шууд хамаарч байв.

Улс төрийн хямралд нөлөөлсөн гадаад, дотоод ерөнхий угтвар нөхцөлийн хүрээнд хямралыг шийдвэрлэхэд чиглэсэн улс төрийн тодорхой үйл ажиллагаа нөхцөлдөн хэрэгжсэн юм. Тэгэхдээ хямралыг шийдвэрлэх үйл явц, хямралын тодорхой угтвар нөхцөлийн үйлчлэл хоёр цаг хугацаа, орон зайн хувьд давхцан хэрэгжсэнээрээ онцлог юм. Улс төрийн хямралын тодорхой угтвар нөхцөл гэдгийг судлаачийн хувьд хямрал, гажуудал үүсэхэд шууд нөлөөлсөн улс төрийн хүчин зүйлсийн цогц нийлбэр, хямралд хүргэх гадаад, дотоод ерөнхий угтвар нөхцөлийн улс төрийн төвлөрсөн илэрхийлэл хэмээн үзэж байгаа юм.

Ийм угтвар нөхцөл 1980-аад оны дунд үеэс Монгол оронд бүрэлдэж эхэлсэн улс төрийн өвөрмөц нөхцөл байдал, улс төрийн үзэгдэл, үйл явцын өрнөлтөөр нөхцөлдөж байлаа. 1980-1990-ээд оны зааг үед улс орны нийгмийн амьдралын бүх салбарт тэр дундаа эдийн засгийн тухайн цаг үеийн бодит байдал, түүний хүрээнд нэгэнт бий болсон зогсонги байдлыг зориудаар нуун хаацайлах аргагүй болж ирэв. Энэ үйл явцад хэд хэдэн бодит учир шалтгаан шууд нөлөөлсөн билээ. Үүнд: нэгд, 1980-аад оны дунд үеэс Дорнод Европын зарим улс орнууд болон манай хойд хөрш ЗХУ-д өрнөж байсан ардчилал, шинэчлэлийн үйл явц; хоёрт, эдийн засгийн хүрээнд дэх “зогсонги байдал”-ын уршгаар ард түмний амьдралын төвшин доройтож, шаардлагын хэмжээнд хүрэхгүй болсон, гуравт, улс төрийн хүрээний хүнд суртал, ардчилсан бус

байдлаас болж олон түмний нийгэм-сэтгэл зүйн хүрээнд шүүмжлэлт уур амьсгал идэвхжих болсон зэрэг нь 1990-ээд оны улс төрийн эрчимтэй өөрчлөлтийг өдөөгч шууд түлхэц болов.

Нэгэнт гадаад талын нөлөөлөл тааламжгүй чиглэлээр өөрчлөгдөж, улс орны нийгмийн сэтгэл зүйд бухимдал, шүүмжлэлт уур амьсгал идэвхжиж эхэлсэн нөхцөлд тухайн цаг үетэйгээ ямар ч боловч зохицож, байдлыг хурцатгахгүй байх нь тэр үеийн эрх баригчдын хувьд маш чухал байлаа. Ийм нөхцөлд өөрчлөлт, шинэчлэлтийг ам хэлээр ч болов дэмжиж, нийгмийн амьдралын олон салбарт нэгэнт бий болсон таагүй байдлыг хагас дутуу ч гэсэн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болсон юм. МАХН-ын XIX их хурлын шийдвэрт энэ байдал тусгалаа олсон байдаг. Энэ их хурал “намын эдийн засгийн бодлогын ойрын жилүүдийн гол зорилт бол нийгмийн үйлдвэрлэлийг давшингуй хөгжүүлэх, үр ашгийг нь дээшлүүлэх энэ үндсэн дээр ард түмний аж - байдлын цаашдын өсөлтийг хангах явдал мөн”⁶⁹ гэж тэмдэглээд энэ зорилтыг хэрэгжүүлэх гол арга зам нь эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх явдал гэж тодорхойлжээ.

Энэ тухай тэр үеийн нам засгийн удирдагч байсан Ж.Батмөнх тус их хурал дээр хэлсэн үгэндээ “Эдийн засаг, нийгмийг ойрын жилүүдэд хөгжүүлэх зорилтыг ийнхүү тодорхойлохдоо Намын Төв Хороо тус улсын эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх явдлыг чиг баримжаа болгож” байгааг дурдсан бол⁷⁰ МҮЭ-ийн XIII их хурал дээр “Өөрчлөн байгуулалт бол манай чиг баримжаа мөн” гэж⁷¹ онцлон тэмдэглэж байсан юм.

Энэ бол нийгэмд цогцолбор шинжтэй өөрчлөлт нэгэнт тулж ирээд байгааг ихээхэн болгоомжилсон хэлбэрээр ч болов улс төрийн хувьд анх удаа хүлээн зөвшөөрсний албан ёсны илэрхийлэл байв. Энэ үед МАХН-ын дээд удирдлага “өөрчлөн байгуулалтын зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг бид өөрсдөө эхэлж, санаачиллаа. Өөрчлөлтийг өөрсдөөсөө эхлэнэ. Намаа шинэчлэнэ гэж 1980-аад оны эцсээс ярьж эхэлсэн байна. Гэвч энэ нь ЗХУ-д яригдаж, хийгдэж байгаа бүхнийг өөрийн орны онцлогт тохируулах нэрийдлээр хүч, эрчийг нь сулруулан, хуулбарлаж, дууриаж сурчихсан МАХН-ын тэр үеийн удирдах бүлгийн ээлжит заль мэх, хоосон амлалт, хуурамчлал төдий зүйл байлаа.”⁷² Харин МАХН-ын Төв Хорооны Ү бүгд хурлаас хойш улс орны хэмжээнд улс төрийн нэн эгзэгтэй нөхцөл байдал бүрэлдэн бий болсон бөгөөд түүний гол онцлог нь:

- ✓ Эрх баригч бүлгийнхний ам, ажил нь зөрж, дэвшүүлэн тавьсан асуудал, түүнийг хэрэгжүүлэх зорилтууд нь тунхаглал төдийгөөс хэтрэхгүй байгаа нь олон түмэнд бодитой мэдрэгдэх болсон;
- ✓ Олон түмний нийгэм- сэтгэл зүйн хүрээнд дургүйцэн бухимдах уур амьсгал газар авч, эрх баригч бүлгийнхний зарим нэг шудрага бус үйлдэл, хүнд сурталт ёсонд шүүмжлэлтэй хандаж, түүнийг ил, тодорхой эсэргүүцэн тэмцэх явдал идэвхжсэн;

⁶⁹ Ж.Батмөнх “МАХН-ын XIX их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан, цаашдын зорилт”. УБ., 1986, 3 дахь тал.

⁷⁰ “МАХН-ын XIX их хурлыг нээж нөхөр Ж.Батмөнхийн хэлсэн үг.”, “МАХН-ын XIX их хурлын материал” УБ., 1986. 6 дахь тал.

⁷¹ “МҮЭ-ийн XIII их хурал дээр Ж.Батмөнхийн хэлсэн үг,” “Намын амьдрал” 1987. № 6, 15 дахь тал.

⁷² Д.Чулуунжав. Монголын нийгмийн өвөрмөц байдалд тохирох төрийн засаглалын зохистой хэлбэр, хэмжээ, бүтэц, үүргийн асуудалд. УБ., 2004, 93-94 дахь тал.

- ✓ Эрх баригч бүлгийнхний үзэл бодол олон түмний санаа бодлын хоорондын зөрөө ялгаа улам бүр гүнзгийрэх болсноор нийгмийн сэтгэл зүйн тогтвортой байдал алдагдан, эрх баригчдад итгэх олон түмний итгэл суларч тэдний нэр хүнд эрс буурч эхэлсэн;
- ✓ Олон түмэн хуучнаараа номхон хүлцэнгүй амьдрах ямар ч сонирхолгүй төдийгүй боломжгүй болж, тэдний улс төрийн идэвх эрс нэмэгдсэн;
- ✓ Хэвлэлд асуудлыг эрс хурцаар тавьж, шүүмжлэлт байр сууринаас бичсэн өгүүлэл материал олноор нийтлэгдэж, олон түмний үнэлэмж баримжааллын хуучин хэв маяг эвдэрч эхэлсэн;
- ✓ Эрх баригч бүлгийнхний орчинтойгоо зохицох, асуудлыг оновчтой шийдвэрлэн зохион байгуулах чадвар, нөөц бололцоо нэгэнт шавхагдсан гэдэг нь мэдрэгдэх болсон;
- ✓ Олон түмэн дургүйцэл бухимдлаа ил тодорхой зохион байгуулалттай хэлбэрээр илэрхийлэх сонирхол аажмаар нэмэгдэх болсон. Улс төрийн хуучин тогтолцоо, засаглалын дотоод дархлал нь суларч түүний легитимт шинж нь алдагдаж эхэлсэн зэргээр тодорхойлогдож байв. Эндээс үзвэл 1980-1990-ээд оны зааг үеийн Монгол орны улс төрийн нөхцөл байдлыг улс төрийн хэм хэмжээ алдагдаж, нийгмийн сэтгэл зүй тогтворгүй болсон үе гэж нэрлэж болох юм. Улс төрийн энэ нөхцөл байдал 1980-аад оны сүүл үеэс Монголд бүрэлдэн бий болсон бөгөөд энэ нь тус оронд нэгэнт ужигран бугшсан улс төрийн хямралыг бодитой нөхцөлдүүлсэн билээ.

Монголд улс төрийн хямрал илэрч, түүнийг шийдвэрлэх үйл ажиллагаа бодитой хэрэгжих болсоны нэг үндсэн илрэл нь улс төрийн шинжтэй сонирхлын бүлэг, эвсэл холбоод байгуулагдан үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж эхэлсэн явдал байв. 1989 оны эцсээр гудамж талбайд тухайн үеийн засаг төрийн бодлоготой үл нийцэх үзэл санаа бүхий ухуулах хуудас наах, түүндээ монголчууд улс төр, оюун санааны олон жилийн хүлээснээс ангижирч, эрх чөлөө, сайн сайхан амьдрал, шударга ёсны төлөө тэмцэх цаг болсныг уриалан сануулж байлаа. Энэ нь тус оронд тодорхой хэсэг, бүлэг хүмүүс улс төрийн үйл ажиллагаагаа нууц явуулж буйг харуулсан гэрч, баримт болж байв. Залуучуудын дунд нийтлэг эрх ашиг, сонирхлын дагуу янз бүрийн хэлбэрээр нэгдэж улс төрийн бодитой үйл ажиллагаа явуулах сонирхол газар авч эхэлсэн байлаа.

Энэ үеэс эхлэн Монголын ард түмний улс төрийн идэвх урьд өмнө байгаагүйгээр сэргэн идэвхжиж, олон жилийн турш оршин тогтнож байсан хүнд сурталт-тоталитар дэглэмийн эсрэг өрнөсөн олон түмний шударга тэмцлийг зохион байгуулалттай хэлбэрт оруулан, хошуучлах зорилго бүхий улс төрийн эвсэл холбоод дараа дараалан байгуулагдав.

Монголд бүрэлдсэн улс төрийн хямралыг шийдвэрлэх үйл явц нь олон түмний улс төрийн идэвх, оролцооны шинж чанарт гарсан өөрчлөлт, шинээр байгуулагдсан эвсэл холбоодын үйл ажиллагааны цаашдын өрнөлт тэдний тавьсан улс төрийн шаардлага, түүнд хандах эрх баригчдын байр суурь, хандлагын идэвхжилтэй холбоотой байлаа. 1980-1990-ээд оны зааг үеийн Монголын олон түмний улс төрийн тэмцэл, үйл ажиллагааны гол онцлог нь

урьдын унтаа байдлаасаа эрс ангижирч, улс төрийн оролцооны идэвхтэй, хурц гэмээр хэлбэрт, шилжсэнээр тодорхойлогдож байлаа. Энэ нь манайд урьд өмнө гарч байгаагүй олон түмний улс төрийн тэмцлийн хэлбэр болох цуглаан, жагсаал, ажил хаялт, улс төрийн суулт, улс төрийн мэтгэлцээн, хэлэлцээр, санал солилцолт, улс төрийн эвсэл холбоодын их хурал, өлсгөлөн зэргээр илэрч байлаа. Харин хүмүүсийн улс төрийн амьдралд оролцох энэ хэлбэрүүд нь тухайн үеийн эрх баригч хүчний улс төрийн бодлого, албан ёсны байр суурьтай харшилж байсан утгаараа улс төрийн хувьд нийцгүй оролцоо болж байв. Гэвч энэ нь хүнд сурталт, захиран тушаах дэглэмийн эсрэг олон түмний ардчилсан шудрага тэмцлийн үндсэн дээр болж байснаараа олон түмний улс төрийн оролцооны зайлшгүй, зүй ёсны хэлбэрүүд болж байсан юм.

Тухайн үед олон нийтийн улс төрийн оролцоо нь гол төлөв бүлгийн шинжтэй буюу улс төрийн эвсэл, холбоодын бие даасан болон хамтын үйл ажиллагаагаар дамжин илэрч байв. Улс төрийн оролцооны ийм хэлбэрийн анхных нь олон улсын хүний эрхийн өдрөөр МоАХ-ноос зохион байгуулсан улс төрийн цуглаан байсан юм.

Монголд улс төрийн хямралыг шийдвэрлэх үйл явц нь улс төрийн нарийн төвөгтэй тэмцлийн зүй ёсны үр дүн байсан бөгөөд хямралыг шийдвэрлэх шаардлагыг түргэтгэхэд олон түмний улс төрийн тэмцэл оролцооны дараах хэлбэр, үйл явдал идэвхтэй түлхэц болсон гэж үзэж болно. Үүнд:

- ✓ Монголын шинээр байгуулагдсан улс төрийн шинжтэй олон нийтийн байгууллага, иргэний хөдөлгөөнүүдийн үйл ажиллагаа өөр хоорондоо уялдан зохицуулагдсан байдлаар өрнөх болсон.
- ✓ Улс төрийн тэмцлийн хэлбэр өөрчлөгдөж улс төрийн суулт, өлсгөлөн гэх зэрэг хурц хэлбэрт шилжин, тавьж буй шахалт шаардлага нь улам бүр шийдэмгий бөгөөд бодитой нийгмийн сэтгэл зүй ихээхэн цочирдсон шинжтэй болсон.
- ✓ Олон түмний улс төрийн идэвхийн хүчтэй өрнөлт, ардчилсан хүчнүүдийн улс төрийн тэмцлийн зоримог хэлбэрүүд МАХН-ын доторхи эрүүл саруул хүчний шахалт шаардлагаар олон жил ноёрхсон нэг намын ноёрхол эцэс болж, хүнд сурталт захиран тушаах тогтолцооны гол цөм МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчоо (УТТ) бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох гарцаагүй нөхцөл бий болсон.
- ✓ МАХН-ын тухайн үеийн удирдлага зохицон нөхцөл байдлыг ойлгон мэдэрч, ардчилсан хүчнийхэнтэй асуудлыг улс төрийн зөвшөлцлийн аргаар яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх боломжийг эрж сүвэгчилж эхэлсэн, эл яриа хэлэлцээг төр, засгийн шинэ удирдлага улам эрчимтэй үргэлжлүүлж, үр дүнд хүрч байсан.
- ✓ Нийгмийн сэтгэл зүйд тогтворгүй хандлага давамгайлж үзэл үнэлэмж, улс төрийн хандлага, байр суурийн эсрэг тэсрэг байдал улам гүнзгийрэн тэр нь улс төрийн оролцооны янз бүрийн

хэлбэрээр өргөн олныг хамран бодитой илрэх болсон зэргийг дурдаж болох юм.

Улс төрийн хямрал шийдвэрлэгдэх үйл явцын нэг чухал хэсэг нь монголд улс төрийн засаглалын ардчилсан тогтолцоо бүрэлдэх улс төр, эрх зүйн орчин бий болж эхэлсэн явдал юм. Төрийн засаглалын ардчилсан тогтоцыг бий болгон тэдгээрт намуудыг тэгш эрхтэйгээр оролцуулах, байнгын ажиллагаатай парламентыг сонгуулиар байгуулан ажиллуулах тухай асуудал ардчилсан хүчнийхний зохион байгуулсан анхны цуглаан, жагсаалаас эхлэн тавигдаж байсан. Энэ асуудалтай холбогдсон тодорхой шаардлагыг анх удаа МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга байсан Ж.Батмөнхөд Ардчилсан Социалист Хөдөлгөөнөөс (АСХ) 1990 оны 2 дугаар сарын 8-нд илгээсэн "Ил захидал"-д албан ёсоор тодорхой тавьсан гэж үзэж байна. Уг захидалд ардчилсан төрийн бүтцийн асуудлыг шилжилтийн шинжтэй Ардын Түр Хурлыг (АТХ) байгуулах замаар эхний ээлжинд шийдвэрлэж болох тухай санаа тусгагдсан байлаа. Тэдний бодож байснаар АТХ-ыг 1990 оны эхний хагаст багтаан сонгуулиар байгуулах, энэ нь Үндсэн хууль, Төрийн сонгуулийн хуулийг боловсруулан ард түмнээр хэлэлцүүлэн баталж улмаар сонгууль явуулах замаар шинэ төрийн тогтолцоог байгуулаад өөрөө огцрох учиртай байв.

Төрийн ардчилсан бүтэц Монгол оронд үүсэн байгуулах улс төрийн үйл явц МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсноор бодитой хэрэгжиж эхлэв. Эл асуудлыг МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал авч хэлэлцээд гаргасан тогтоолдоо "МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүд, орлогч гишүүд, нарийн бичгийн дарга нар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрохоор бүгд хуралд оруулсан саналыг ёсоор болгосугай"⁷³ гэжээ.

Ингэснээр тус оронд бий болоод байсан улс төрийн хямралыг шийдвэрлэх улс төрийн шууд бөгөөд тодорхой нөхцөл бүрэлдэх үйл явцад шийдвэрлэх томоохон алхам хийгдсэн байна. Цоо шинээр бүрэлдэн бий болох төрийн засаглалын ардчилсан бүтцийн үндсэн зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлоход АИХ-ын 11 удаагийн сонгуулийн VIII чуулган түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн юм. АИХ-ын 11 дэх удаагийн сонгуулийн VIII чуулганаас Монгол улсын төрийн дээд байгууллагын бүтцийн тухай асуудлыг авч хэлэлцээд 1990 оны 3 дугаар 23-ны өдрийн тогтоолдоо: "БНМАУ-ын төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага нь АИХ, хууль тогтоох байгууллагын дээд байгууллага нь Улсын Бага Хурал байх, Улсын Ерөнхийлөгчийн албан тушаал бий болгохоор БНМАУ-ын Үндсэн хуулийн зохих бүлгийг өөрчлөн боловсруулж төслийг ард нийтээр хэлэлцүүлэхийг БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдэд даалгахаар..." болов.⁷⁴

Харин төрийн байгууллагын энэхүү бүтцийг сонгож бүрдүүлэх талаар улс төрийн хүчнүүд "Дугуй ширээний" ярилцлагын явцад зарчмын хувьд тохиролцсон байдаг. Тухайлбал, 1990 оны 5 дугаар сарын 5-нд болсон хэлэлцэгч талуудын дугуй ширээний ярилцлага явцад гаргасан хамтарсан

⁷³ "МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал" УБ., 1990, 28 тал.

⁷⁴ П.Очирбат, "Тэнгэрийн цаг", 1996, 142 дахь тал.

протоколд "БНМАУ-ын иргэн хууль ёсоор бүртгэгдсэн аль намыг дэмжиж байгааг тэдгээр намын нэрийн жагсаалтын (сонгуулийн) хуудсаар тус орны нийт сонгогчдын саналыг нууцаар хураах замаар тодорхойлсны үндсэн дээр БНМАУ-ын Бага Хурлын гишүүдийг намуудаас нэр дэвшүүлж БНМАУ-ын АИХ сонгоно. БНМАУ-ын иргэн сонгогчдоос намуудын төлөө өгсөн нийт саналын дүнд санал хураах нэрийн жагсаалтанд орсон тухайн намын авсан саналын эзлэх хувийг БНМАУ-ын Бага Хурлын гишүүдийн тоонд тэр намын эзлэх мандатын тоог тодорхойлно. УБХ-ын гишүүдийн мандатыг ийнхүү намуудад хуваарилсны дараа сонгуульд оролцсон нам бүр УБХ-д өөрийн эвслийг төлөөлөн суух гишүүдийн нэрийг дэвшүүлнэ"⁷⁵ гэжээ. Улс төрийн хүчнүүдийн "дугуй ширээний" хамтарсан хэлэлцээний явцад хэлэлцэж тохиролцсон зарчмын энэ тохиролцоо АИХ-ын II дэх удаагийн сонгуулийн IX чуулганаас баталсан БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулиар албан ёсоор баталгаажин хүчин төгөлдөр хэрэгжих бололцоотой болов. Үүгээр Монголд төрийн ардчилсан бүтцийг бүрдүүлэх, улс төр, эрх зүйн ерөнхий орчин бий болов.

Энэ бүхнээс үзвэл, Монголын ард түмэн 1980-1990 ээд оны зааг үед тодрон илэрсэн улс төрийн хямралыг шийдвэрлэсэн хэлбэр, арга зам нь хувьсгалт өөрчлөлтийн арга байсан бөгөөд тэгэхдээ энэ нь хүчирхийлэлийн бус, харин хувьсгалын тайван хэлбэр байсанаараа онцлогтой байна. Хямралыг шийдвэрлэх арга хэлбэр нь хувьсгал байлаа гээд түүний илрэх хэлбэр нь заавал ч үгүй зэвсэгт хүчирхийллийн хэлбэрээр илрэх албагүй юм. Харин энэ нь тухайн улс оронд үүссэн хямралын онцлог, тухайн цаг үеийн нөхцөл байдал, тохироо, эрх баригч хийгээд тэмцэгч бүлэг, хэсгийн хоорондын харилцааны шинж байдал зэргээс хамааран тайван хэлбэрээр хийгдэх бололцоотой. Яг ийм нөхцөл тохироо 1980-1990-ээд оны зааг үе болон 1990-оны Монголын ардчилсан хувьсгалын өрнөлтийн эгзэгтэй агшинд бүрэлдсэн юм. Ийм нөхцөлд Монголын ард түмэн хямралыг мөргөлдөөн болгон хурцатгахгүйгээр тайван хэлбэрээр хийж чадсан. Энэ бол тухайн үед эрх барьж байсан хүчний ухамсартай хэсгийн эх оронч зоримог шийдвэр, оролцоо, шинээр бүрэлдсэн нам хүчнүүдийн зөв зүйтэй, шударга шаардлага тэмцлийн аль алиных нь үр дүн байсан юм. Ингэхлээр 1990-ээд онд Монголд өрнөсөн ардчилсан хувьсгал нь Монголын бүх ард түмэн, тухайн үеийн бүх нам, хүчний хамтын хүч чармайлтын үр бүтээл байсан юм.

Сүүлийн үед Монголын нийгэмд хувьсгал хийх тэр тусмаа хувьсгалт хүчирхийллийг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлага, тохироо нэгэнт бүрэлджээ гэж үзэх улс төрчид, судлаачид гарч ирэх боллоо. Гэвч энэ саналыг судлачийн зүгээс хүлээн зөвшөөрөх бодолгүй байна. Өнөөдөр монголд хувьсгал биш, харин хувьсгалын үр дүнтэй дүйхүйц хэмжээний зоримог шинэчлэлт, эрс тууштай реформ хэрэгтэй байна. Учир нь бид хийх ёстой хувьсгалаа нэгэнт хийсэн бөгөөд одоо харин нийгмийг ардчиллын суурин дээр бэхжүүлэн шинэчилж, төлөвшүүлэх л хэрэгтэй байгаа юм. Энэ дашрамд улс төрийн хямралыг авч үзэх

⁷⁵ Мөн тэнд, 149 дахь тал.

“хувьсгалын хандлага”⁷⁶ –ын тухайд цөөн зүйлийг тодруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Дэлхий ертөнц социализм, капитализм гэсэн хоёр системд хуваагдсанаар хувьсгалыг тайлбарлах дараах хоёр үндсэн хандлага бий болсон гэж үздэг. Эхнийх нь хувьсгал гэдэг нь олон түмний хүчийг ашиглан нийгмийн хөгжлийн хууль, түүхийг өөрчлөх үйл явц гэж үздэг бол харин хувьсгалыг тайлбарлах удаах хандлага нь түүнийг нийгмийн хөгжлийг сааруулан түүнд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйл гэж үздэг хандлага юм. Хувьсгалыг авч үзэх эхний хандлага нь түүний улс төр, үзэл суртлын үүргийг чухалчилсан бол хоёр дахь хандлага нь хувьсгалын явцад үүсэх сөрөг үр дагаврыг нь илүүтэй онцлон үздэгтэй холбоотой байна.

Хувьсгалыг өөрчлөх хүч хэмээн үздэг хандлагын талынхан нийгмийн хувьсгалын тухай Лениний онолын загварт их төлөв суурилдаг. Энэ хандлагыг практик талаас нь авч үзвэл энэ нь зөвхөн ажилчин ангийн хувьд ач холбогдолтой бөгөөд түүнийг улс төрийн системийн хувьд хаалттай, хагас хаалттай улс орны хувьд хийх бололцоотой байгаа юм. Тэд их төлөв ийм хувьсгалыг хийхэд цэрэг, арми шийдвэрлэх нөлөөтэй гэж үздэг. Тухайн цаг үед социалист системийн улс орнуудад нийгмийн гол үзэл суртал болж байсан социалист үзэл санаа нь нийгмийн гишүүдийн нийтээрээ хүлээн зөвшөөрсөн нийтлэг үзэл суртал байсан. Тухайлбал үндэсний эрх чөлөөний хувьсгал гэх энэ загвар нь ангийн хувьсгал гэдэг нэр томъёотой салшгүй холбоотойгоор судлагдсаар ирсэн байдаг.

Харин хувьсгалыг нийгмийн сөрөг үйл явц гэж тайлбарладаг хандлага нь нийгмийн тогтвортой байдлыг бусниулахад хүргэдэг хувьсгалыг аядуу зөөлөн замаар явуулах эсвэл түүнийг бүр хийхгүй байсан нь дээр гэсэн үзэл баримтлалд суурилсан байдаг. Иймээс энэ хандлагыг хувьсгалыг тайлбарлах хүчирхийллийн бус аядуу хандлага хэмээн үздэг. Өнгөрсөн зууны 1970-1980-аад онд нийгэмд тогтвортой байдлыг аядуу, хүчирхийллийн бус зөөлөн арга замаар хэрэгжүүлэх боломжийн талаарх судалгаа шинжилгээний ажил нилээд их хийгдсэн байдаг.

Хувьсгалын асуудлаар тусгайлан судалгаа хийсэн барууны зарим судлаачдын бүтээлээс үзэхэд түүний онолын хөгжилд дөрвөн үеийг бий болгосон байдаг. Үүний нэг дэх үед хувьсгалын үүсэн бий болох шалтгаан, тохироо, нөхцөлийн талаар зөвхөн судалгаа хийсэн байдаг. Харин хоёр дахь үед хувьсгалын талаарх онолын чиг хандлагуудыг бий болгож, улмаар хямралын дотоод болон гадаад хүчин зүйл, харилцан зөрчилдсөн байдалд анхаарлаа хандуулж, хувьсгалын практик болон онолын ач холбогдлыг тодорхойлсон байдаг. Тэгвэл гурав дахь үед буюу XX зууны 70-80-аад онуудад нийгмийн улс төр, эдийн засгийн системд сөргөөр нөлөөлж, түүний хөгжлийг сааруулж байдаг хувьсгалт арга хэлбэрийн талаарх судалгаа голлон хийгдэж, хувьсгал хийхэд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл юу болох эсэх талаар нарийвчлан

⁷⁶ Барсамов В.А. Цветные революции: теоретический прикладной аспекты. // Социологические исследования. 2006. №8. с.57-66

шинжлэхийг эрмэлзэж байлаа. Харин судалгааны дөрөв дэх үед хувьсгалыг судлахдаа тэдгээрийг системтэйгээр харьцуулан судлах онолын шинэ чиг хандлагыг голчлон баримжаа болгох болсон байна.

ДҮГНЭЛТ

Орчин үед нийгмийг хувьсгалд уриалахаасаа илүүтэй түүнийг хийснээр гарч болох үр дагавар тодруулбал нийгэмд тогтвортой болон тогтвортой бус байдлын чухам аль нь үүсч болох, хувьсгалын анхдагч учир шалтгаан гэдэгт чухам юуг, ямар хүчин зүйлийг голлон ойлгох эсэх, нийгэмд зайлшгүй өөрчлөлт хийх тохиолдолд хувьсгалыг уу аль эсвэл түүнтэй дүйцэхүйц хэмжээний эрс шинэчлэл, реформыг уу? гэдгийг туйлын нухацтай судлах болсоныг анхааран харгалзах хэрэгтэй байгаа юм. Өнөөдөр хувьсгалыг тайлбарлах субъектив, марксист-ленинист, бүтэц-үүргийн, элитийн, нийгэм-сэтгэл зүйн гэх зэрэг олон хандлагууд байсаар байгаа хэдий ч тэдгээртэй зэрэгцэн орчин үед хувьсгал хэмээх энэ нэр томъёог тайлбарлах онолын олон шинэ хандлага гарч ирэх болсон. Энэхүү хандлага чиглэлийн онолын гол зарчим нь хувьсгалыг хүчирхийлэлийн бус, харин тайван, эрс шинэчлэлтийн арга зам, хэлбэрээр хэрэгжүүлэх бололцоотой гэдгийг нотлож байгаад оршиж байна.

Түлхүүр үг: Улс төрийн хямрал, Монголын нийгэм-улс төрийн хямрал, хямралыг шийдвэрлэсэн арга

Товч хураангуй: Улс төрийн төрийн хямрал нь дэлхий нийтийн үзэгдэл юм. Харилцан хамаарал бүхий өнөөгийн ертөнцөд хямралт үзэгдэл нь тодорхой бүс нутаг, улс орны хүрээнээс хальж, дэлхий нийтийн шинжтэй болж хувирах эсвэл дэлхий нийтийг хамарсан хямрал тодорхой улс орны хүрээнд нөлөөлөн өргөжих нь нийтлэг үзэгдэл. Иймд тодорхой бүс нутаг, улс орны хүрээнд илэрч болох улс төрийн хямралт үзэгдэл түүнтэй холбоотой асуудлыг нарийвчлан шинжлэх нь улс төрийн хямрал судлалын тулгамдсан асуудал төдийгүй улс төрийн шинжлэх ухааны хойшлуулшгүй чухал шаардлага даруй мөн. Энэ үүднээс үзвэл Монгол дахь улс төрийн хямралын асуудал нь Монголын улс төр шинжлэлийн онол, практикийн ач холбогдол бүхий асуудал болох нь илэрхий юм.

ABSTRACT

This paper is an analysis of the Mongolian socio-political crisis and its reason, consequences. It focuses on a 1980-1990's political condition. Any decision is made by a government that has owned whole social information. Although Mongolia involved in democratic current from 1992, Mongolian political system has long history. So in this article I try to reveal socio-economic situation of 1980-1990.

НОМ ЗҮЙ

1. Болд-Эрдэнэ. Д. Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил. / хоёр дахь хэвлэл / УБ., 2008
2. Батмөнх.Ж. Хүч хэрэглэж хэрхэвч болохгүй. УБ.,2001
3. Зардыхан. К, Чулуунбаатар. Г. Социализм уу?, Эсвэл хөгжлийн гажил уу?. УБ.,1991
4. Монголын нийгмийн өөрчлөлт. / Ред: Б.Даш-Ёндон / УБ., 2008
5. Монголын ардчиллын төлөвшил./ Ред:Г.Чулуунбаатар, Д.Болд-Эрдэнэ / УБ., 2011
6. Чулуунбаатар. Г. XX,XXI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. УБ.,2009
7. Чулуунбаатар. Г. XX,XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, хөгжил. УБ.,1999
8. Чулуунжав.Д. Либеральчлал ба ардчиллын нөхцөл дэх Монголын төрийн тогтолцоо, байгууламж, засаглал, үйл ажиллагааны хууль, эрх, улс төр, философийн орчин үеийн тулгуур асуудлууд. УБ., 2009